

Монгол Улсын Консерваторийн Захирлын
2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн
А/20 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН КОНСЕРВАТОРИД БАГШ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ⁸

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Консерваторид (цаашид Консерватори гэнэ) багш сонгон шалгаруулж авах, профессор, дэд профессор, хүндэт профессор, ахлах багш, багш, дадлагажигч багш, гэрээт багш ажиллуулахад Боловсролын тухай хууль, “Дээд боловсролын тухай” хууль, “Их дээд сургууль, коллежийн багшид тавигдах нийтлэг шаардлага” бусад холбогдох хууль тогтоомж, Консерваторийн дүрэм, журам болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.

НЭГ. МОНГОЛ УЛСЫН КОНСЕРВАТОРИЙН БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 1.1 Консерваторийн багш нь мэргэжлийн баялаг туршлагатай, онолын гүнзгий мэдлэгтэй, оюуны өндөр чадамжтай, судалгааны болон заах арга зүй эзэмшсэн, сургалт, уран бүтээл, эрдэм шинжилгээний ажлыг хослуулан гүйцэтгэх чадвартай, мэдээллийн технологийн ололтыг ашигладаг, мэдлэг чадвараа дээшлүүлэхэд санаачилгатай ажилладаг, залуу уран бүтээлчдийг сурган хүмүүжүүлэх туршлагатай, багшийн ёс зүйг эрхэмлэдэг уран бүтээлч, судлаач багш байна.
- 1.2 Консерваторийн багш нь магистраас доошгүй эрдмийн зэрэг цолтой байна.
- 1.3 Консерваторийн багш нь 5-аас дээш жил мэргэжлээрээ ажилласан уран бүтээлч, судлаач багш байна.
- 1.4 Мэргэжлийн багш нь зөвхөн боловсролын баримт бичиг дээрх /диплом/-ээр олгосон мэргэжлээр ажиллана.
- 1.5 Консерваторийн багш нь мэргэжил дээшлүүлэх, уран бүтээл, сургалт, судалгааны ажлын төлөвлөгөө гарган тэнхим, профессорын багийн хурлаар хэлэлцүүлэн, мэргэжлийн сургуулийн захиралтай гэрээ байгуулж ажиллана.
- 1.6 Консерваторийн багш нь гадаад хэлээр мэргэжлийн ном, сурах бичиг, сэтгүүл, гарын авлага ашиглах чадвартай байна.
- 1.7 Гадаадад зочин багшаар ажиллах, мэргэжил дээшлүүлэх, суралцахаар явахдаа багш Консерваторитай гэрээ байгуулах ба гэрээний хугацааг нэг удаа сунгаж болно. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээний хугацаа хэтрүүлбэл ажилд эргэн орох асуудлыг шинэ багшийн адил сонгон шалгаруулалтаар шийдвэрлэнэ.
- 1.8 Мэргэжлийн багш нь хоёр жилд нэг удаа бүрэн хэмжээний бие даасан уран бүтээл туурвина.
- 1.9 Мэргэжлийн суурь болон ерөнхий суурь хичээлийн багш нь Консерваторид ажилласнаас хойш 10 жилийн дотор докторын (Ph.D) зэрэг хамгаалсан байна.
- 1.10 Консерваторийн багшийн ажлыг гурван жил тутамд аттестатчилна.
- 1.11 Мэргэжлийн багш нь суралцагчтай тогтвортой ажиллах бөгөөд суралцагчийг зөвхөн хүндэтгэн үзэх шалтгаанаар өөр багшид шилжүүлнэ.
- 1.12 Консерваторийн үндсэн багшид давхар ажил эрхлэхийг хориглох ба шаардлагатай тохиолдолд сургуулийн захиргаанд хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.

⁸ Төслийг ГХТХА-ны дарга Ц.Шаравдэрэн боловсруулав.

ХОЁР. КОНСЕРВАТОРИД БАГШ СОНГОН ШАЛГАРУУЛАХ

- 2.1. Консерваторийн багшид тавигдах шаардлагыг бүрэн хангасан, тухайн салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн, тайзны болон тоглолтын баялаг туршлагатай, өндөр ур чадвартай, мэргэжлийн хөгжимчин, дуучин, бүжигчин, циркийн жүжигчин зэрэг **тухайн улс, олон улсын хэмжээнд өндрөөр үнэлэгдсэн улсын алдар цолтой уран бүтээлч, урлаг судлалын ухааны докторын зэрэгтэй эрдэмтнийг сонгон шалгаруулалтгүй авч ажиллуулж болно.**
- 2.2. Консерваторид үр бүтээлтэй ажиллаж байгаад докторантурын сургалтад хамрагдаж эрдмийн зэргээ амжилттай хамгаалсан багшийг үргэлжлүүлэн **сонгон шалгаруулалтгүй авч ажиллуулж болно.**
- 2.3. Консерваторид олон жил өндөр үр бүтээлтэй ажилласан эсвэл уран бүтээлийн болон Эрдмийн ажлын туршлагатай тэтгэврийн насны багш нарыг эрдмийн зөвлөл, мэргэжлийн сургуулийн санал, Захирлын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн, **75%, 50%, 25%-ийн цагийн ачаалалтай гэрээт багшийн** орон тоонд захирлын тушаалаар ажиллуулна.
- 2.4. Консерваторийн урилгаар ажиллах багшийг тухайн гэрээнд тусгасан нөхцөлөөр ажиллуулна.
- 2.5. Консерваторид мэргэжлийн ёс зүй, ур чадвар, сурган хүмүүжүүлэх заах арга зүйн туршлагатай, Их дээд сургууль, коллежийн багшид тавигдах нийтлэг шаардлагыг хангасан багшийг нээлттэй сонгон шалгаруулалтаар авна.
- 2.6. Багш шинээр авах асуудлыг багш дутагдалтай байгаа тэнхимийн саналыг үндэслэн жил бүрийн VI, XII-р сард захирлын тушаалаар томилогдсон ажлын хэсэг/захиргаа, СБЗГ болон мэргэжлийн тэнхимээс бүрдсэн/ сонгон шалгаруулалтыг зохион байгуулна. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд хичээлийн жилийн дундуур сонгон шалгаруулалтыг зохион байгуулж болно.
- 2.7. Консерваторийн багш нь үндсэн болон гэрээт багш байна. Үүнд:
 - 2.7.1. **Үндсэн багш:**
Сонгон шалгаруулалтад тэнцсэн багш
Мэргэжлийн өндөр ур чадвартай уран бүтээлч эсвэл эрдэмтэн /гадаад дотоод/ багшийг урилгаар ажиллуулах
 - 2.7.2. **Гэрээт багш:**
Гэрээт багш нь 75%, 50%, 25%-ийн цагийн ачаалалтай байна.
- 2.8. Багшийг сонгон шалгаруулалтаар авахад дараах зарчмыг баримтална.
 - 2.8.1. Багш сонгон шалгаруулах зарыг тэнхим, мэргэжлийн сургууль, захирлын зөвлөлийн саналд үндэслэн шалгаруулалт эхлэхээс гурваас доошгүй долоо хоногийн өмнө нийтийн хэвлэл болон сургуулийн цахим хуудаснаа нийтэлнэ. Зарлан нийтлэх ажлыг Консерваторийн хүний нөөцийн мэргэжилтэн хариуцна.
 - 2.8.2. Зарлалд ажлын байрны нэр, бүрдүүлэх бичиг баримт, багшийн заах хичээл, уран бүтээлийн болон эрдэм шинжилгээний ажлын чиглэл, эрдмийн зэрэг, гадаад хэлний мэдлэг, мэргэжлээрээ ажилласан жил, нас зэрэг сонгон шалгаруулалтад тавигдах нийтлэг болон тусгай шаардлагыг дурдсан байна.
- 2.9. Сонгон шалгаруулалтад орох багш бүртгүүлэхээр ирэхдээ дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:
 - Боловсролын диплом, багшлах эрхийн үнэмлэх
 - Төрийн албан хаагчийн анкет
 - Урьд нь ажиллаж байсан албан газрын ажил байдлын тодорхойлолт
 - Эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт
 - Уран бүтээлийн жагсаалт
 - Иргэний үнэмлэх
 - Цээж зураг

- Цагдаагийн газрын тодорхойлолт
- 2.9.1. Хүний нөөцийн мэргэжилтэн бүртгэлийг заасан хугацаанд явуулах ба бүртгэлийн дутаар, овог нэр, төгссөн сургууль, иргэний үнэмлэхийн дутаар, холбоо барих утас, цахим хаяг, бүртгэсэн огноо, цагийг тэмдэглэж, оролцох хүмүүст энэ журмыг танилцуулна.
- 2.10. Сонгон шалгаруулалтын болзол хангасан ажил горилогчдоос Консерваторийн захирлын тушаалаар байгуулсан шалгалтын комисс мэргэжлийн шалгалт авна. Үүнд:
 - 2.10.1. *Мэргэжлийн багийн сонгон шалгаруулалтад оролцогчид:*
 - Ур чадварын шалгалт (1-2 төрөл-жанрын бүтээл хөгжимдөх, дуулах, бүжиглэх)
 - Багшлах ур чадварын шалгалт (20-30 минутын мэргэжлийн хичээл, Бүжгийн багш дасгалжуулагч, Циркийн багийн мэргэжлийн ажлын туршлага дээр үндэслэх)
 - 2.10.2. *Мэргэжлийн суурь болон ерөнхий суурь хичээлийн багийн сонгон шалгаруулалтад оролцогчид:*
 - Ярилцаа, бичгийн /эсээ/ шалгалт зохион байгуулж, сургалт эрдэм шинжилгээний бүтээлд үнэлгээ өгнө.
 - Багшлах ур чадварын шалгалт (20-30 минутын хичээл)
- 2.11. Сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдээс нэгдсэн журмаар мэдээлэл технологи, гадаад хэлний мэдлэгийн шалгалт авах бөгөөд шалгалт тус бүрд 70 ба түүнээс дээш хувийн үнэлгээ авсан бол тэнцсэнд тооцно.
- 2.12. Улсын болон олон улсын мэргэжлийн уралдаанд тэргүүн, дэд байрын шагналыг мэргэжлийн ур чадварын шалгалтаас чөлөөлж болно.
- 2.13. Консерваторид гадаад хэлний багшаар ажиллах хүсэлтэй иргэд олон улсын хэмжээнд нийтлэг хэрэглэдэг түвшин тогтоох шалгалтын (TOEFL, iBT, IELTS ба бусад) боломжит оноог сүүлийн хоёр жилийн хугацаанд авсан бол шууд тооцно.
- 2.14. Сонгон шалгаруулалтын дүнгээр болзол хангасан багшийг Захирлын зөвлөлийн хуралд танилцуулж, захирлын тушаалаар томилно.
- 2.15. Сонгон шалгаруулалтад тэнцсэн багшийг 1-3 жил хүртэл хугацаагаар дадлагажигч багшаар ажиллуулж, ажлын үр дүн, тэнхим, мэргэжлийн сургуулийн саналыг харгалзан ажлын үр дүнг дараах шалгууруудын дагуу үндсэн багшаар авах асуудлыг Захирлын зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ. Үүнд:
 - 2.15.1. Ерөнхий соёл ба харилцааны чадвар
 - Багш нь үндсэн хууль, Боловсролын тухай хууль болон бусад хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бүх шатны аливаа шийдвэр, дүрэм, стандартыг мөрддөг, сурталчилдаг, хэрэгжүүлдэг байх;
 - Суралцагчийн хөгжил, төлөвшилийн тасралтгүй өсөлтийг буюу сургалтын ажлын үр дүнг оновчтой, бодитой, тодорхойлон тухайн нөхцөл, орчин, нөөцөд тулгуурлан тодорхой үр дүнд хүргэх, сургалтын үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй бодитой төлөвлөдөг, үр ашигтай зохион байгуулдаг, манлайлан удирддаг, тогтмол хянан сайжруулдаг зэрэг сургалтын менежерийн үндсэн чадваруудыг эзэмшсэн байх;
 - Багшийн ёсзүйн дүрмийг сахин биелүүлдэг, ёсзүйн өндөр хариуцлагатай байх;
 - Боловсролын харилцаанд оролцогсдыг дэмжин тэднийг хүндэтгэж, эрхийг нь дээдэлдэг байх;
 - Хүмүүстэй харилцан зөвшилцөж чаддаг, тэдний зан үйлд нөлөөлөх сурган хүмүүжүүлэх эв дүйг эзэмшсэн байх;
 - Хамт олны дунд эвсэг нөхөрсөг зан байдлыг эрхэмлэн бусад багш нартай хамтран ажиллаж тэднээс байнга суралцдаг байх;
 - 2.15.2. Бүтээлч чадвар

- Сургалтад шинэ арга технологийг нэвтрүүлэн өөрийн үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандаж бүтээлч шинэ санаа, санаачилга дэвшүүлэн ажил үүргийг шуурхай гүйцэтгэж, үйл ажиллагаандаа бодитой хандах ажил хэрэгч чанарыг эзэмшсэн байх;
- Шинэ мэдээлэл, технологийг эрэлхийлэн, тэдгээрийг дамжуулах биш суралцагчдын хэрэгцээнд тохируулан боловсруулж, практикт хэрэгжүүлэх талаар бүтээлчээр сэтгэж ажилладаг байх;
- Сургуулийн ерөнхий зорилго, зорилтод нийцүүлэн сургалтын лаборатори, кабинет тоноглох, тохижуулах болон өөр бусад хэлбэрээр сургууль хөгжүүлэх ажилд хувь нэмрээ оруулдаг байх.

2.15.3. Мэргэжлийн ур чадвар

Онолын талаар:

- Дээд боловсролын сургалтын байгууллагын багш нь багшлах эрх (сертификат) авсан байхын зэрэгцээ үндсэн мэргэжлийн хичээл заахын тулд магистраас доошгүй боловсролын зэрэгтэй байх;
- Уран бүтээлч хүний хүчин зүйл, нөөц бололцоог бүрэн дүүрэн илрүүлж, хөгжүүлэн тэдний үйл ажиллагаа, харилцаа, хамтын ажиллагааг зөв зохицуулдаг, багш өөрөө уран бүтээлч, өөрийн урын сантай гэх мэт бүх талын үлгэр дуурайл үзүүлдэг байх;
- Урлаг, хөгжмийн боловсрол, боловсрол судлал, сэтгэл судлалын ухааны арга зүйг эзэмшиж, судалгааны үндсэн дээр сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн, заах арга, сургалтын арга зүйг боловсронгуй болгож тодорхой чиглэлээр бусад багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг бие даан буюу бусадтай хамтран зохион байгуулдаг сургалтын технологич байх;

2.15.4. Судалгаа шинжилгээний чадвар

- Урлагийн, хөгжмийн ухааны судалгаа, шинжилгээний арга зүйг эзэмшсэн тодорхой чиглэлээр судалгааны ажил, төсөл хөтөлбөр боловсруулж ажилладаг байх;
- Сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, урлагийн байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулан явуулах ажлын арга барилд суралцсан байх;
- Дотоод гадаадын төсөл, судалгааны ажилд оролцдог байх;

2.15.5. Бусад

- Сургалтын зорилгоо хүрсэн үр дүнтэй нь олон талаас нь харьцуулдаг, цаашид сургалтын чанарыг сайжруулах арга замыг тодорхойлдог байх;
- Багш өөрөө тасралтгүй суралцаж өөрийн мэдлэг боловсрол, сургалтыг удирдах арга барилыг байнга дээшлүүлж, сургах үйл ажиллагааны технологийг шинэчлэн ур чадварын өндөр түвшинд ажилладаг байх;
- Суралцагчийг хайрлан хүндэтгэж, тэдэнд өөрийн нь давуу талыг нь мэдрүүлж, суралцах, өөрийгөө удирдах, хөгжүүлэх талаарх аргыг заан сургадаг байх;
- Компьютерыг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглан интернэтийн мэдээллийг авч мэдлэг, туршлагаа баяжуулдаг чадвартай байх;

2.16 Дадлагажигч багшийг төрийн үйлчилээний 9 дүгээр зэрэглэлээр /ТҮ-9/ цалинжуулна.

ГУРАВ. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОХ БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1. Мэргэжлийн Төгөлдөр хуур, Утсан хөгжим, Цөөхүүл хөгжмийн тэнхимд багшаар орох хүсэлтэй багшийг 1-3 жил цагийн багшаар ажиллуулах бөгөөд цагийн багш нараас дараах үзүүлэлтүүдээр тэнхимийн багш нарын саналыг үндэслэн дадлагажигч болон үндсэн багшийн зэрэглэлд дэвшүүлэн ажиллуулна. Үүнд:

- Мэргэжлийн хөгжимдөх ур чадвар /багшаар орсон эхний 3 сарын дотор 3 төрөл хэлбэрээс доошгүй бие даасан концерт/
 - Төгссөн сургуулийн дипломын үр дүн, улсын шалгалтын программ
 - Товч намтар болон гаргасан амжилтууд /тайлан болон төрөл бүрийн оролцсон концертууд, олон улсын болон улсын чанартай уралдаануудад амжилттай оролцсон эсэх, суралцах хугацаандаа тэргүүний сурагч байсан эсэх
 - Концертмейстр багшаар олон жил амжилттай ажилласан багш нараас Цөөхүүл хөгжмийн тэнхимд сонгон шалгаруулалтгүйгээр авч ажиллуулж болно.
- 3.2. Ерөнхий төгөлдөр хуурын тэнхим:
- Төгөлдөр хуурч, хөгжмийн багш мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй;
 - Мэргэжлээрээ 3-аас дээш жил ажилласан туршлагатай байх;
- 3.3. Үндэсний хөгжмийн тэнхим:
- Мэргэжлийн сургууль төгссөн байх;
 - Мэргэжлээрээ 3-аас дээш жил ажилласан туршлагатай байх;
 - Багшлах ажлын туршлагатай байх;
 - Гадаадын болон дотоодын мэргэжлийн уралдаанд оролцсон байдал, гаргасан амжилтууд;
- 3.4. Үлээвэр, Цохивор хөгжмийн тэнхим:
- Мэргэжлийн сургууль төгссөн байх, дипломын мэргэжлийн хичээлийн үр дүн 85% доошгүй байх;
 - Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх;
- 3.5. Бүжгийн тэнхим:
- Мэргэжлийн шаталсан сургууль төгссөн байх;
 - Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх;
- 3.6. Концертмейстр:
- Төгөлдөр хуурч мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх;
 - Нот шууд харж хөгжимдөх ур чадвартай байх;
- 3.6.1. Бүжгийн концертмейстрт тавигдах шаардлага:
- Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх;
 - Чөлөөт сэтгэмжээр /импровизаци/ хөгжимдөх ур чадвартай байх;
- 3.7. Циркийн тэнхим:
- Хөгжим бүжгийн коллеж төгссөн байх;
 - Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх;
 - Мэргэжлээрээ гаргасан амжилтууд
- 3.8. Дуулаачийн тэнхим:
- Мэргэжлийн шаталсан сургалттай сургууль төгссөн байх;
 - Мэргэжлийн урлагийн байгууллагад 10-аас дээш жил ажилласан байх;
 - Дуулах ур зүйн цагийн болон дадлагажигч багшаар 1-3 жил ажиллаж багшлах ур чадвараа таниулсан байх;
 - Хөгжмийн боловсрол болон дуулаачийн хоолойн онцлогийн онол практикийн мэдлэгтэй байх;
 - Дуулах урлагтай холбоотой гадаад хэлний мэдлэгтэй байх /Итали, Орос, Франц, Герман/
 - Мэргэжлээрээ гаргасан амжилтууд
- 3.9. Хөгжмийн ухааны тэнхим:
- Гадаад дотоодын мэргэжлийн хөгжмийн суурь боловсролыг эзэмшсэн байх /Мэргэжлийн хөгжмийн дунд боловсрол/

- Мэргэжлийн суурь шалгалт авна /хөгжмийн онол, соноршуулга, хөгжмийн түүх, гармонь, хөгжмийн шинжлэл/
- Тухайн заах хичээлийн чиглэлээр шалгалт авна /жишээ нь: олон хоолойн ухаан, дорно дахины хөгжмийн түүх, ардын уран бүтээл, зэмсэг судлал, хөрвүүлэг, удирдвар уншвар гэх мэт/.

---oOo---